

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.06.07

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	Авлигатай тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	1.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төсөл боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлэн үнэлүүлж тайлагнах;	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөг аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон агентлагийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж 14 зорилгын хүрээнд 50 арга хэмжээг төлөвлөн аймгийн Ерөнхий эрх бүхий албан тушаалтнаар хянуулж, тус байгууллагын даргаар 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг гаргаж файлаар ГЗБГЗЗГ-т болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.	100
		1.2. Батлагдсан төлөвлөгөөг олон нийтэд сурталчлах арга хэмжээг зохион байгуулах;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	Батлагдсан төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас www.dundgovi.gazar.gov.mn/ болон аймгийн www.dundgovi.gov.mn цахим сайтад мөн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шудрага ёс, хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарт тус тус байршуулж олон нийтэд сурталчилсан.	100

2	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох.	2.1. Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах;	Байршуулсан тушаал шийдвэрийн тоо	29	25	Тус байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой (барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс томилсон тушаал, цаг үеийн байдалтай холбогдуулан гаргасан тушаал) 17 тушаал шийдвэрийг байгууллагын цахим хуудас /www.dundgovi.gazar.gov.mn/-ны Үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт тухай бүр байршуулсан.	100
		2.2. Үйл ажиллагаандаа мөрдөж буй дүрэм, журам, шийдвэрийн жагсаалтыг цахим хуудсанд тухай бүр шинэчлэн байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Үйл ажиллагаанд мөрдөж байгаа Газрын харилцааны чиглэлийн 16, барилга хот байгуулалтын чиглэлийн 34 хууль, засгийн газрын тогтоол, сайдын тушаал, дүрэм, журмын тухай мэдээллийг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn , цахим сайтад болон газрын удирдлага болон барилга, хот байгуулалтын хэлтсийн мэдээллийн самбарт байршуулсан. Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр шийнэчлэгдэх тухай бүрт баяжуулалтыг хийж байна.	100
		2.3. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Иргэд үйлчлүүлэхэд шаардагдах газрын харилцааны чиглэлийн 10, барилга хот байгуулалтын чиглэлийн 2 бичиг баримтын жагсаалт болон газрын төлбөр хураамжийн талаарх мэдээллийг газрын удирдлага болон барилга, хот байгуулалтын хэлтсийн мэдээллийн самбарт мөн байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn , цахим сайтын Газрын удирдлага болон барилга, хот байгуулалт цэсэнд байршуулсан. 2022 онд газрын төлбөр тогтоосон ИТХ-ын шийдвэр шинэчлэгдэж батлагдсныг цахим сайт болон мэдээллийн самбарт шинэчилсэн.	100

		2.4. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	“Газрын төлбөрийн хувь хэмжээ тогтоох тухай” аймгийн ИТХ-ын тогтоолын төсөлд иргэдийн саналыг авахаар www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудасны Хууль тогтоомж хэсгийн “Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төсөл” хэсэгт байршуулсан. Цахимаар авсан санал асуулгад аймгийн төвийн сум болох Сайнцагаан сумын газрын төлбөрийн итгэлцүүрийн хувь хэмжээг тогтоох санал асуулгад 22 иргэн, Сайнцагаанаас бусад сумдын газрын төлбөрийн итгэлцүүр, хувь хэмжээнд 48 иргэн санал ирүүлсэн. Иргэдээс ирүүлсэн саналыг тогтоолын төсөлд тусгасан.	100
3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	3.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;	-Мэдээлэл хүргэсэн сувгийн тоо -Байршуулсан мэдээллийн тоо	3 төрлийн мэдээллийн суваг 40 мэдээлэл	3 төрлийн мэдээллийн суваг 50 мэдээлэл	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлигын хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах, мэдээлэл сурталчилгаа явуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагууд хүлээсэн байдаг. Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас иргэдэд зориулсан богино хэмжээний видео, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаартай утасны сурталчилгааны шторк, 14 төрлийн видео шторкыг иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах зорилгоор тус байгууллагын фэйсбүүк хуудас , байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шудрага ёс, хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбар, байгууллагын коридорт байрлах ухаалаг дэлгэц зэрэг 3 төрлийн сувгаар тус байгууллагаас үйлчилгээ авч байгаа	100

						бүх иргэдэд сурталчилж байна. Тайлант хугацаанд нийт 18 удаа мэдээллийг шинэчлэн байршуулсан. Мөн Авлигатай тэмцэх газрын фэйсбүүк хуудсанд бүх албан хаагчдыг, тус байгууллагаар үйлчлүүлсэн 150 гаруй иргэдийг нэгдүүлсэн.	
		3.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	4	Авлигатай тэмцэх газраас “Зөв зөвд шудрага зөв” сэдэвт соён гэгээрүүлэх аяныг 21 аймаг, орон нутагт хэрэгжүүлж байна. Уг арга хэмжээний хүрээнд: - “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгад бусад төрийн байгууллагуудыг уриалан нэгдэж, стент хэвлүүлэн байгууллагын коридорт байрлуулсан. - Албан хаагчид “Дундговь авлиггүй хөгжинө” стикертэй зургаа байгууллагын фэйсбүүк хуудсанд байршуулж иргэд олон нийтийг авлигаас ангид байхыг уриалсан. - АТГ-аас бэлтгэсэн шторк зурагт хуудсуудыг цахимаар болон мэдээллийн самбараар иргэдэд сурталчлан ажиллаж байна.	100
		3.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” самбарыг байгууллагын коридорт байршуулсан ба мэдээллийг тогтмол шинэчилж байна. Тайлант хугацаанд самбарын мэдээллийг 4 удаа шинэчилсэн.	100
		3.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинэлэг ажлыг санаачлан хэрэгжүүлэх	Арга хэмжээний тоо	1	1	- Газрын кадастрын цахим систем болох www.egazar.gov.mn сайтыг сурталчлах иргэдэд зориулсан гарын авлага дээр Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах	100

						110 дугаарыг сурталчилж байршуулсан. - Байгууллагын логон дээр 110 дугаарыг сурталчилсан наалтыг хэвлүүлж өрөөнүүдийн гадна нааж, тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд тараасан.	
4	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	4.1. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад хамрагдсан байх	-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	16	16	Авлигатай тэмцэх газраас 2022 оны 01 дүгээр сард төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан цахим сургалтад 2 албан хаагч, төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх авлигын эсрэг давтан сургалтад тус байгууллагын 16 албан хаагч цахимаар хамрагдсан.	100
5	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	5.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж тайлагнасан байх;	-Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Зөвлөмж ирээгүй	100	Тус байгууллагад Авлигатай тэмцэх газраас зөвлөмж ирүүлээгүй болно.	100
6	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	6.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байх;	-Зарласан уриа, аянд нэгдэж арга хэмжээ зохион байгуулсан тоо	3	3	Авлигатай тэмцэх газраас “Зөв зөвд шудрага зөв” сэдэвт соён гэгээрүүлэх аяныг 21 аймаг, орон нутагт хэрэгжүүлж байна. Уг аяны хүрээнд “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлж дараах арга хэмжээг зохион байгуулж байна. Үүнд: - Гомдол, мэдээлэл хүлээн авах-110 дугаарыг сурталчилсан зурагт хуудсыг байгууллагын “Шудрага ёс,	100

						хөгжил дэвшилд-110” самбарт байршуулсан. - Авлигын эсрэг тв шторк, инфографик, теле зохиомж, зурагт хуудсыг байгууллагын мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж байна. - Авлигатай тэмцэх газрын фэйсбүүк хуудсанд бүх албан хаагчдыг, тус байгууллагаар үйлчлүүлсэн 150 гаруй иргэдийг нэгдүүлсэн.	
	6.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан гэрээний тоо	6	10	Барилга угсралтын ажлын захиалагчийн хяналтын гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх заалтыг нэмэлтээр тусгасан. Тайлант онд захиалагчийн хяналтын 7 гэрээг баталгаажуулсан байна.	100	
	6.3. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг цахим хэлбэрээр хянуулж, томилогдсон албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулах;	-ХАСУМ-ийг цахимаар хянуулсан албан тушаалтны тоо -ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлсэн албан тушаалтны тоо	5	5	Тайлант хугацаанд 2 албан тушаалтны ХАСУМ-ийг цахимаар хянуулсан боловч тухайн албан тушаалд томилоогүй. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд хамаарах албан тушаалтан тус байгууллагад 5 байдаг ба Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ АТГ-т шинэчлэн гаргадаг.	100	
	6.4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	-Зөрчил үүссэн, үүсч болзошгүй мэдэгдэл,	75	80	Тайлант хугацаанд албан тушаалтнуудаас тус байгууллагад 80 мэдэгдэл тайлбар гаргасан ба мэдэгдэл тайлбарыг тухай бүр	100	

		урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гаргаж, ЭБАТ цэсний бүртгэлүүдийг бүрэн хөтөлж, дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.	тайлбарыг гаргасан тоо			www.iaac.meduuleg.mn сайтын ЭБАТ цэсэнд бүртгэсэн. Барилга, байгууламж ашиглалтад оруулах комисст орсон албан тушаалтнууд тус байгууллагад мэдэгдэл гаргадаг ба тендерт оролцох, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаанд оролцохдоо албан хаагчид ашиг сонирхлын мэдэгдэх хуудсыг харьяа байгууллагуудад гаргадаг.	
		6.5. Авлигын эсрэг байгууллагын соёлыг төлөвшүүлэх, удирдлагын манлайлал үзүүлэх, санаачилга өрнүүлэх.	Санаачилсан арга хэмжээний тоо	1	1	- Авлигатай тэмцэх газрын фэйсбүүк хуудсанд бүх албан хаагчдыг, тус байгууллагаар үйлчлүүлсэн 150 гаруй иргэдийг нэгдүүлсэн. - Газрын кадастрын цахим систем болох www.egazar.gov.mn сайтыг сурталчлах иргэдэд зориулсан гарын авлага дээр Авлигатай тэмцэх газрын гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилж байршуулсан. - Байгууллагын логон дээр 110 дугаарыг сурталчилсан наалтыг хэвлүүлж өрөөнүүдийн гадна нааж, тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд тараасан.	100
7	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	7.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх; (Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	1	1	- Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, олон нийтэд ил тод байдлыг хангах зорилгоор Газрын харилцааны үйлчилгээ цахимжиж Газрын удирдлагын нэгдсэн систем www.egazar.gov.mn-ийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Ингэснээр салбарын албан хаагчдын үйл ажиллагаа иргэдэд ил тод нээлттэй болж, бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцож үйл ажиллагаагаа уялдуулсан. Мөн иргэд хаана байгаагаас үл хамааран	100

						газрын харилцаатай холбоотой хүсэлт гаргах, төлөвлөгөөнд санал өгөх, өөрт хамаарах газартай холбоотой мэдээлэл авах, хяналт тавих боломж бүрдсэн. - Байгууллагын коридорт иргэд газрын харилцааны үйлчилгээг цахимаар авах цахим мэдээллийн буланг тохижуулж компьютер, тоног төхөөрөмж байршуулсан.	
		7.2. Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх;	Гүйцэтгэлийн хувь	-	100	Авлигын шинжтэй, сонирхлын зөрчилтэй асуудал гараагүй болно.	100
		7.3. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх;	Гүйцэтгэлийн хувь	-	100	Албан хаагчид албан үүргээ гүйцэтгэх явцад авлигатай холбоотой аливаа асуудалтай тулгараагүй ба эрх бүхий албан тушаалтанд мэдээлэл ирээгүй байна.	100
		7.4. Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж мөрдүүлэх;	Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэмтэй танилцсан албан тушаалтны тоо	16	16	Төрийн албаны салбар зөвлөлөөс “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг тус байгууллагын албан хаагчдад зохион байгуулсан. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын албан хаагч бүрт танилцуулж, танилцсан талаар гарын үсэг зуруулсан. Ёс зүйн дүрмийг байгууллагын мэдээллийн самбар болон www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудасны Ил тод байдлын “Хүний нөөцийн <i>ил тод байдал</i> ” хэсэгт байршуулсан.	100
8	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй	8.1. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;	Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо	151	151	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, 2022 оны төсөв, төсвийн гүйцэтгэл,	100

	байдлыг сайжруулах	8.2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4; 8.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах;				улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга байгууламжийн талаарх мэдээллийг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудас болон байгууллагын фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт тухай бүр байршуулан тогтмол шинэчилж байна. Дээрх чиглэлээр цахимд 86 удаа, мэдээллийн самбарт 18 удаа, нийт 104 удаа мэдээллийг шинэчилсэн.	
9	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх.	9.1. Төсөв, санхүүгийн тайланг сар, улирал жилээр хугацаанд нь гаргаж холбогдох дээд байгууллагад тайлагнах; 9.2. Тухайн жилийн төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор байршуулах; 9.3. Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 1-ний дотор байршуулах; 9.4. Сарын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 8-ны дотор байршуулах; 9.5. Улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 8-ны дотор байршуулах; 9.6. Хагас жилийн төсвийн гүйцэтгэл; 9.7. Хагас жилийн санхүүгийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор байршуулах; 9.8. Дараа жилийн төсвийн төслийг 8 дугаар сарын 15-ны дотор байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	2021 оны санхүүгийн тайланг тайлант хугацаанд гаргаж Дундговь аймаг дахь төрийн аудитын газраар баталгаажуулан ГЗБГЗЗГ болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан. Шилэн дансны мэдээллийг www.dundgovi.gazar.gov.mn сайтны Ил тод байдал цэсний Шилэн данс хэсэгт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дүгээр заалтын мэдээллийг тайлант хугацаанд бүрэн байршуулсан. 2022 оны төсвийн хуваарийг цаг тухайд нь байршуулсан. Сар улирлын төсвийн гүйцэтгэл, 2021 оны санхүүгийн тайлан, 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн орлого бүрдүүлэлт, хандив тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн	100

		9.9. Жилийн эцсийн санхүүгийн тайланг 5 дугаар сарын 1-ний дотор байршуулах; 9.10. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор байршуулах; 9.11. Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт багтааж мэдээлэх; 9.12. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгож /татварын орлого, татварын бус орлого/ мэдээлэх; 9.13. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтыг тайлагнах (Бүтэн жилээр, хагас жилээр); 9.14. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)-г мэдээлж байршуулах; 9.15. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)-ийг байршуулж мэдээлэх;				бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээлэл зэргийг цаг тухай бүр нь шилэн дансны мэдээлэлд байршуулсан. Хугацаа хоцорч байршуулсан мэдээлэл байхгүй болно.	
--	--	---	--	--	--	--	--

		9.16. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг мэдээлэх;					
10	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.	10.1. Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн байх/;	-Цахим хуудсанд байршуулсан сул орон тооны зарын тоо	2	2	Сул орон тооны захиалгыг аймгийн ТАСЗ-д 1 удаа хүргүүлсэн ба сул орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудас www.dundgovi.gazar.gov.mn/ , мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэсэн.	100
		10.2. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журмын хэрэгжилтийг хангах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө түүний хэрэгжилтийг хангах, ил тод байршуулах	Хэрэгжилтийн хувь	100	100	Тус байгууллагын “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” /2022-2025/-ийг 4 зорилтын хүрээнд, “Албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг 5 зорилтын хүрээнд шинэчлэн боловсруулж байгууллагын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/13 дугаар тушаалаар батлуулсан. Уг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг агентлагийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж байгууллагын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт 100 хувьтай байна. Дээрх хөтөлбөр, төлөвлөгөө, түүний хагас жилийн хэрэгжилтүүдийг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудасны Ил тод байдлын “Хүний нөөцийн ил тод байдал” байдал хэсэгт байршуулсан.	100
		10.3. Байгууллагын батлагдсан орон тоонд	Өөрчлөлтийг мэдээлсэн тоо	1	1	Байгууллагын бүтэц орон тоонд өөрчлөлт ороогүй ба батлагдсан	100

		орсон өөрчлөлтийг тухай бүр ил тод, нээлттэй мэдээлэх;				бүтцийг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудасны Ил тод байдлын “Хүний нөөцийн <i>ил тод байдал</i> ” байдал хэсэгт байршуулсан.	
11	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.	11.1. Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэл, албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Албан хаагчдын нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь , батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудасны Ил тод байдал цэсний “Хүний нөөцийн <i>ил тод байдал</i> ” хэсэгт байршуулсан. Мөн байгууллагын коридорт албан хаагчдын танилцуулгыг байршуулсан.	100
		11.2. Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах	Гүйцэтгэлийн хувь	-	100	Тайлант хугацаанд төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа байхгүй байна.	100
12	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах.	12.1. Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх /утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр/;	Шийдвэрлэлтийн хувь	100	100	Иргэдээс өргөдөл, гомдол, саналыг байгууллагын нээлттэй утас болох 70592555 дугаарын утсанд болон коридорт байрлах санал хүсэлтийн хайрцаар, байгууллагын пэйж хуудсаар хүлээн авдаг. Тайлант хугацаанд тус байгууллагад хандаж иргэдээс 158 өргөдөл гомдол ирүүлсний 113 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн ба албан хаагчтай холбоотой санал, гомдол ирээгүй болно.	100
		12.2. Дотоод ажил, санал, өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн	Гүйцэтгэлийн хувь	100	100	Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь болон өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах мэргэжилтэн Д.Болорчимэгийн овог, нэр, утасны дугаар, албан тушаалыг тус мэргэжилтний өрөөний үүдэнд болон	100

		хуваарийг ил тод, нээлттэй байршуулах;				байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	
		12.3. Иргэдийн өргөдөл гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх;	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн тоо	4	4	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тайланг улирал бүр маягтын дагуу гаргаж ЗДТГ-ын мэргэжилтэн н.Жавзмаад файлаар хүргүүлдэг. Өргөдөл гомдлын 2022 оны 1,2 дугаар улирлын мэдээг байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт тус бүр байршуулсан.	100
13	Тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох.	13.1. Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг ил тод, нээлттэй байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Засгийн газрын 2021 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийн дагуу тайлант хугацаанд 11 барилга байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, баяжуулалт хийн ажиллаж байна.	100
		13.2. Тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг ил тод, нээлттэй байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Засгийн газрын 2021 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийг байгууллагын цахим хуудсанд болон мэдээллийн самбарт иргэд олон нийтэд ил тод байршуулсан.	100
		13.3. Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг ил тод, нээлттэй байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан иргэн, ААН-ийн бүртгэл болон зөвшөөрөл олгосон хугацаа, дуусах хугацааны талаарх мэдээллийг улирал бүр шинэчилж байгууллагын мэдээллийн самбарт байршуулдаг.	100

14	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах.	14.1. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах;	Гүйцэтгэлийн хувь	100	100	Тайлант хугацаанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний талаарх мэдээллийг сар бүр шилэн дансанд байршуулсан.	100
Дундаж хувь							100

ХЯНАСАН:

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ГАЗРЫН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ, ТАТВАРЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН (ЭБАТ)

Д.БОЛОРЧИМЭГ